

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2026/159/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2026 оны 02 дүгээр сарын 09</p> <p>2026</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Бүнчинсүрэн</p> <p>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn</p>
---	--

НЭГ.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/24
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтад заасан "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар"-ийг баримтлаагүй, БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан А/35/А/10/9 тушаалын 8 дэх "Багш ажилтныг үнэлж

6426050099

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухай байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ" гэсэн заалтууд, УСНББОУС-1 Санхүүгийн толилуулга, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Хүүхдэд ээлтэй сургалтын орчны зардлаас "Ялалт агууших" ХХК-тай 31,200.0 мянган төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмжийг шууд гэрээ байгуулан худалдан авсан.
- Ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг томилолгүйгээр захирлын тушаалаар тайлант онд багш, ажилтнуудад 25,822.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон.

Асуудлыг онцолсон хэсэг

Тухай байгууллагын биет бус хөрөнгөд 14,730 м² газар бүртгэлтэй, газрын гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn)-д 16,892 м² 3 төрлийн газар бүртгэлтэй байгаа бөгөөд 2,162 м² газар нь орон сууцны хотхоны цэвэр бохир ус, эрчим хүч, дулааны шугам явж байгаа бөгөөд ашиглах боломжгүй газар байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 19 зорилтын хүрээнд 84 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 97.2 хувиар үнэлсэн байна.

Тус сургууль нь 2025 онд улсын хэмжээнд анхдагч боловсролын системийн MNS ISO 21001:2001 стандартыг нэвтрүүлэх эрх авах ажлын хүрээнд ажлын хэсэг томилогдон 3 сарын хугацаанд сургуулийн нийт хамт олны хүчээр сургалтын орчныг сайжруулах ажлыг эрчимтэй зохион байгуулж, багш ажилчид өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан засвар үйлчилгээг хийж сайжруулсан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР / Б.МӨНХБАТ



ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>477,307,344.50</u>	<u>345,043,420.03</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	252,852,884.69	81,459,971.82
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	252,852,884.69	81,459,971.82
3121	Төгрөг	252,852,884.69	81,459,971.82
31211	Төрийн сангийн харилцах	252,852,884.69	81,459,971.82
33	АВЛАГА	350,000.00	200,000.00
335	Бусад авлага	350,000.00	200,000.00
3351	Байгууллагаас авах авлага	350,000.00	200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	224,104,459.81	263,383,448.21
351	Түүхий эд материал	89,293,674.31	84,625,662.76
35110	Тусгай зориулалттай материал	89,293,674.31	84,625,662.76
354	Хангамжийн материал	134,810,785.50	178,757,785.45
35410	Бичиг хэргийн материал	840,000.00	635,000.00
35420	Аж ахуйн материал	2,005,809.00	8,376,709.00
35470	Бусад хангамжийн материал	131,964,976.50	169,746,076.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,607,762,936.43</u>	<u>2,489,491,484.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,607,762,936.43	2,489,491,484.50
392	Биет хөрөнгө	2,235,000,436.31	2,117,631,484.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,085,043,408.24	2,085,043,408.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	-280,337,533.48	-327,922,140.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	647,292,641.54	661,477,961.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-291,601,223.38	-413,273,914.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	154,286,575.23	143,487,920.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	-88,290,494.01	-62,745,946.17
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	194,732.56	194,732.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,636,471.60	54,701,427.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-30,224,141.99	-23,331,964.81
393	Биет бус хөрөнгө	372,762,500.12	371,860,000.16
39301	Програм хангамж	8,939,860.00	8,939,860.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,427,359.88	-5,329,859.84
39303	Бусад биет бус хөрөнгө	368,250,000.00	368,250,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,085,070,280.93</u>	<u>2,834,534,904.53</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>52,945,223.00</u>	<u>50,297,148.03</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	52,945,223.00	50,297,148.03
413	Өглөг	52,945,223.00	50,297,148.03
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,204,475.00	00.00
4136	Бусад өглөг	51,740,748.00	50,297,148.03
41361	Байгууллагад төлөх өглөг	51,740,748.00	50,297,148.03
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,032,125,057.93</u>	<u>2,784,237,756.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,032,125,057.93	2,784,237,756.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,627,034,865.06	1,627,034,865.06
51101	Өмч: - төрийн	1,627,034,865.06	1,627,034,865.06
512	Хуримтлагдсан үр дүн	551,687,497.30	303,800,195.87
51210	Өмнөх үеийн үр дүн	551,687,497.30	551,687,497.30
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-247,887,301.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	853,402,695.57	853,402,695.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,085,070,280.93</u>	<u>2,834,534,904.53</u>

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,690,169,387.60	4,032,467,520.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	168,269,787.60	85,903,920.23
120	Нийтлэг татварын бус орлого	168,269,787.60	85,903,920.23
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	124,608,019.60	11,401,290.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,746,350.00	11,401,290.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	3,280,049.20	38,913,095.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	00.00	35,589,535.23
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,521,899,600.00	3,946,563,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,206,983,900.00	3,601,315,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,206,983,900.00	3,601,315,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	314,915,700.00	345,247,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	314,915,700.00	345,247,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,604,238,941.56	4,280,354,821.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,604,238,941.56	4,280,354,821.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,490,402,538.44	4,224,254,947.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,479,306,941.91	2,958,777,031.27
210101	Үндсэн цалин	1,446,615,904.96	1,713,996,521.91
210102	Нэмэгдэл	736,167,800.50	876,927,574.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	87,030,000.00
210104	Урамшуулал	296,523,236.45	280,822,934.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	289,029,021.28	364,636,414.65
210201	Тэтгэврийн даатгал	192,013,097.48	245,132,798.05
210202	Тэтгэмжийн даатгал	25,350,501.23	30,131,132.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,672,925.79	15,045,100.66
210204	Ажилгүйдлийн даатгал	12,678,350.88	14,920,753.85
210205	Эрүүл мэндийн даатгал	46,314,145.90	59,406,630.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	307,326,896.88	324,748,705.67
210301	Гэрэл, цахилгаан	13,912,066.88	18,958,025.67
210302	Түлш, халаалт	264,915,248.00	269,409,292.00
210303	Цэвэр, бохир ус	28,499,582.00	36,381,388.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,776,264.57	45,264,138.83
210401	Бичиг хэрэг	32,897,392.00	26,277,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,282,522.57	00.00
210404	Ном, хэвлэл	2,032,900.00	10,978,646.83
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	8,007,892.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	9,963,450.00	00.00
2105	Нормативт зардал	59,497,613.00	192,893,085.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,209,040.00	570,130.00
210502	Хоол, хүнс	55,288,573.00	192,322,955.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,675,700.00	19,569,320.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,287,000.00	00.00
210604	Урсгал засвар	17,388,700.00	19,569,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,966,278.18	38,271,876.45
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,966,278.18	38,271,876.45
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	242,823,822.62	280,094,375.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,623,167.00	35,129,968.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	175,200,655.62	243,464,406.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,836,403.12	56,099,874.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,738,800.00	51,856,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	69,811,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,927,300.00	51,856,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	97,603.12	4,243,674.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,603.12	4,243,674.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	85,930,446.04	-247,887,301.43
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	85,930,446.04	-247,887,301.43

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,537,645,950.00	3,957,964,890.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,746,350.00	11,401,290.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,746,350.00	11,401,290.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,746,350.00	11,401,290.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,746,350.00	11,401,290.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,521,899,600.00	3,946,563,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,206,983,900.00	3,601,315,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,206,983,900.00	3,601,315,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	314,915,700.00	345,247,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	314,915,700.00	345,247,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,455,025,670.94	4,043,077,942.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,455,025,670.94	4,043,077,942.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,285,900,694.82	3,794,655,113.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,478,102,466.91	2,959,981,506.27
210101	Үндсэн цалин	1,445,411,429.96	1,714,431,250.18
210102	Нэмэгдэл	736,167,800.50	877,697,321.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	87,030,000.00
210104	Урамшуулал	296,523,236.45	280,822,934.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	289,379,021.28	364,486,414.65
210201	Тэтгэврийн даатгал	192,013,098.08	245,332,798.05
210202	Тэтгэмжийн даатгал	25,350,501.23	30,131,132.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,672,925.79	15,045,100.66
210204	Ажилгүйдлийн даатгал	12,678,350.88	14,920,753.85
210205	Эрүүл мэндийн даатгал	46,664,145.30	59,056,630.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	307,326,896.88	324,748,705.67
210301	Гэрэл, цахилгаан	13,912,066.88	18,958,025.67
210302	Түлш, халаалт	264,915,248.00	269,409,292.00
210303	Цэвэр, бохир ус	28,499,582.00	36,381,388.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,491,200.00	16,255,320.00
210604	Урсгал засвар	7,491,200.00	16,255,320.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,239,078.18	50,824,899.95
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	49,239,078.18	50,824,899.95
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,362,031.57	78,358,267.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	132,894,639.57	59,962,267.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,467,392.00	18,396,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	169,124,976.12	248,422,829.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	169,027,373.00	244,179,155.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	125,100,073.00	192,322,955.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,927,300.00	51,856,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	97,603.12	4,243,674.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,603.12	4,243,674.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	82,620,279.06	-85,113,052.87
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	65,469,252.00	86,279,860.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,469,252.00	86,279,860.00
2200	Дотоод эх үүсвэрээр	65,469,252.00	86,279,860.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	65,469,252.00	86,279,860.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-65,469,252.00	-86,279,860.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,151,027.06	-171,392,912.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	235,701,857.63	252,852,884.69
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	252,852,884.69	81,459,971.82

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	900,013,939.78	-12,164,068.60	2,514,884,736.24
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,627,034,865.06	900,013,939.78	-12,164,068.60	2,514,884,736.24
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,194,879.00	1,194,879.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	853,402,695.57	551,687,497.30	3,032,125,057.93
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	853,402,695.57	551,687,497.30	3,032,125,057.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,627,034,865.06	853,402,695.57	551,687,497.30	3,032,125,057.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-247,887,301.43	-247,887,301.43
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	853,402,695.57	303,800,195.87	2,784,237,756.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,618,285,400.00	3,601,315,900.00	16,969,500.00	99.5%
Улсын төсвөөс санхүүжих	3,618,285,400.00	3,601,315,900.00	16,969,500.00	99.5%
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	345,247,700.00	341,004,025.67	4,243,674.33	98.8%
Орон нутгийн төсвөөс	345,247,700.00	341,004,025.67	4,243,674.33	98.8%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	271,439,200.00	11,401,290.00	260,037,910.00	4.2%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,882,800.00	11,401,290.00	14,481,510.00	44.0%
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	245,556,400.00	00.00	245,556,400.00	0.0%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,234,972,300.00	3,953,721,215.67	281,251,084.33	93.4%
Ажиллагчидтай холбогдсон зардал	3,389,150,800.00	3,324,467,920.92	64,682,879.08	98.1%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,012,578,300.00	2,959,981,506.27	52,596,793.73	98.3%
Үндсэн цалин	1,870,369,400.00	1,714,431,250.18	155,938,149.82	91.7%
Нэмэгдэл	966,778,000.00	877,697,321.11	89,080,678.89	90.8%
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	87,030,000.00	-87,030,000.00	#DIV/0!
Урамшуулал	175,430,900.00	280,822,934.98	-105,392,034.98	160.1%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	376,572,500.00	364,486,414.65	12,086,085.35	96.8%
Тэтгэврийн даатгал	256,069,200.00	245,332,798.05	10,736,401.95	95.8%

Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тэтгэмжийн даатгал	30,125,700.00	30,131,132.00	-5,432.00	100.0%
ҮОМШӨ-ний даатгал	15,063,000.00	15,045,100.66	17,899.34	99.9%
Ажилгүйдлийн даатгал	15,063,000.00	14,920,753.85	142,246.15	99.1%
Эрүүл мэндийн даатгал	60,251,600.00	59,056,630.09	1,194,969.91	98.0%
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	575,321,000.00	556,467,052.62	18,853,947.38	96.7%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	328,991,700.00	324,748,705.67	4,242,994.33	98.7%
Гэрэл, цахилгаан	19,500,000.00	18,958,025.67	541,974.33	97.2%
Түлш, халаалт	270,258,700.00	269,409,292.00	849,408.00	99.7%
Цэвэр, бохир ус	39,233,000.00	36,381,388.00	2,851,612.00	92.7%
Эд хогшил, урсгал засварын зардал	16,256,000.00	16,255,320.00	680.00	100.0%
Урсгал засвар	16,256,000.00	16,255,320.00	680.00	100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,999,900.00	50,824,899.95	1,175,000.05	97.7%
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	51,999,900.00	50,824,899.95	1,175,000.05	97.7%
Бараа үйлчилгээний бусад зардал	178073400.00	164638127.00	13,435,273.00	92.5%
Бараа үйлчилгээний бусад зардал	159,673,200.00	146,242,127.00	13,431,073.00	91.6%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,400,200.00	18,396,000.00	4,200.00	100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	270500500.00	244179155.00	26,321,345.00	90.3%
Бусад урсгал шилжүүлэг	270,500,500.00	244,179,155.00	26,321,345.00	90.3%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	218,644,300.00	192,322,955.00	26,321,345.00	88.0%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,856,200.00	51,856,200.00	0.00	100.0%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,234,972,300.00	4,125,114,128.54	109,858,171.46	97.4%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	252,852,884.69	00.00	0.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	81,459,971.82	00.00	0.0%
БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.0%
Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.0%
АЖИЛЛАГСАДЫН ТОО	102.00	98.00	4.00	96.1%
Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0%
Гүйцэтгэх ажилтан	85.00	84.00	1.00	98.8%
Үйлчлэх ажилтан	16.00	13.00	3.00	81.3%
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,414.00	1,426.00	-12.00	100.8%
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,414.00	1,426.00	-12.00	100.8%
Төрийн өмчит ЕБС	1,414.00	1,426.00	-12.00	100.8%
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	102.00	99.00	3.00	97.1%
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	81.00	80.00	1.00	98.8%
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	21.00	19.00	2.00	90.5%

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 61,022.1 мянган төгрөгийн нэг зөрчил¹ илэрсэнд 61,022.1 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчлийг арилгах албан шаардлага, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 61,022.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 33,623.8 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Албан шаардлага

3.1.1. Сургуулийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/68 дугаар тушаалаар "Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн гишүүдэд болон 2025 оны жилийн эцсийн өмч хөрөнгийн тооллогыг гүйцэтгэсэн ажлын хэсэгт 2,250.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө.", 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа, зөрчлийг таслан зогсоож, Төрийн хэмнэлтийг хуулийг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

3.1.2. Ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг томилолгүйгээр захирлын тушаалаар тайлант онд багш, ажилтныг 25,822.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан А/35/А/10/9 тушаалын 8 дахь "Багш ажилтныг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухай байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа, зөрчлийг таслан зогсоож, багш, ажилтны ур чадварыг олгохдоо хуулийн тогтоомжийн дагуу олгож байх албан шаардлагыг хүргүүлэв.

3.1.3 Тухай байгууллагын биет бус хөрөнгөд 14,730 м² газар бүртгэлтэй, газрын гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn)-д 16,892 м² 3 төрлийн газар бүртгэлтэй буюу газрын хэмжээ зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах

3.1.4. Хүүхдэд ээлтэй сургалтын орчны зардлаас 54,380.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн бөгөөд байгууллагын хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг бэлтгэж эрэмбэлээгүй, "Ялалт агууших" ХХК-тай 31,200.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Засгийн газрын

2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтад заасан "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар"-ийг баримтлаагүй, Боловсролын сайдын А/249 тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан "Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 2 дугаар зүйлийн 2.2.2.1-т "Шаардлагатай тоног төхөөрөмжийн хэрэгцээнд үндэслэн байгууллагын түвшинд хэрэгцээг эрэмбэлж, төсвийн төвлөрүүлэн болон ерөнхийлөн захирагчид хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний шаардлага хэрэгцээг тодорхойлон эрэмбэлж хамт олноороо хэлэлцүүлж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байх албан шаардлагыг хүргүүлэв.

3.1.5. Сургуулийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/69 дугаар тушаалаар ёс зүйн дэд хорооны гишүүдэд 4 дүгээр улирлын мөнгөн урамшуулалд 1,750.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө.", 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Багш, ажилчдад үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлснөөс ажлын хөлс, урамшуулал олгохгүй байх, Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

3.2. Зөвлөмж

3.2.1. Нягтлан бодогч цалингийн зардлыг нягтлан бодох бүртгэлд бичихдээ мөнгөн сууриар бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө." гэсэн заалт, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг нягтлан бодох бүртгэлийн програмтай холбон бичилтийг хийж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэг томилолгүйгээр захирлын тушаалаар тайлант онд багш, ажилтныг 25,822.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.	1	25,822.1			1	25,822.1		
Тухай байгууллагын биет бус хөрөнгөд 14,730 м2 газар бүртгэлтэй, газрын гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn)-д 16,892 м2 3 төрлийн газар бүртгэлтэй буюу газрын хэмжээ зөрүүтэй байна	1	0			1	0		
Хүүхдэд ээлтэй сургалтын орчны зардлаас 54,380.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн бөгөөд байгууллагын хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг бэлтгэж эрэмбэлээгүй, "Ялалт агууших" ХХК-тай 31,200.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.	1	31,200.0			1	31,200.0		
Нягтлан бодогч цалингийн зардлыг нягтлан бодох бүртгэлд бичихдээ мөнгөн сууриар бүртгэсэн.	1	0					1	0
Нийт дүн	4	57,022.1			3	57,022.1	1	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Сургуулийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/68 дугаар тушаалаар "Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн гишүүдэд болон 2025 оны жилийн эцсийн өмч хөрөнгийн тооллогыг гүйцэтгэсэн ажлын хэсэгт 2,250.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.	1	2,250.0	1	2,250.0		
Сургуулийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/69 дугаар тушаалаар ёс зүйн дэд хорооны гишүүдэд 4 дүгээр улирлын мөнгөн гишүүдэд 1,750.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.	1	1,750.0	1	1,750.0		
Дүн	2	4,000.0	2	4,000.0		

-----oO-----